



Bank of Mongolia

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх: Типологи, жишээ, асуудлууд

Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны дарга

Б.Төмөрбат

2012.12.20



Bank of Mongolia

Агуулга

1. Мөнгө угаахын тодорхойлолт
2. Типологи, жишээнүүд
3. Монгол Улсын асуудлууд



“I tell you everything that is really nothing, and nothing of what is everything, do not be fooled by what I am saying. Please, listen carefully and try to hear what I am not saying” ~ poet Charles C. Finn

“Би Та бүхэнд үнэндээ юу ч биш бүх юмны, бүх юмны юу ч биш зүйлийн талаар яриж өгье. Миний яриж байгаа зүйлд битгий хууртаарай. Гагцхүү, анхааралтай сонсоод миний ярихгүй байгаа зүйлийг олж сонсохыг хичээгээрэй” ~ яруу найрагч Чарльз С. Финн

МОНГОЛЫН ХАМГААГАХ, ХӨРСӨӨХ, ХАМГААХ, ХӨРСӨӨХ



МӨНГӨ УГААХЫН ТОДОРХОЙЛОЛТ

- ❑ Маш энгийн үгээр бол хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг хууль ёсны харагдуулах үйл ажиллагааг мөнгө угаах гэж ойлгож болно.
- ❑ Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.1. дэх заалтад: “мөнгө угаах” гэж хууль бусаар олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж, түүний гарал үүслийг нуун далдалж уг эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хууль ёсны болгох зорилгоор гүйлгээнд оруулахыг хэлнэ гэж
- ❑ Эрүүгийн хуулийн 166¹ зүйлд “Хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах, түүнчлэн аливаа этгээдийг хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор энэ хуулийн 166 дугаар зүйлд зааснаас бусад хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө, мөнгийг санаатайгаар хүлээн авсан, хадгалсан, ашигласан, шилжүүлсэн, хувиргасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж тус тус тодорхойлсон байдаг

МОНГОЛ УЛСЫН
МӨНГӨ УГААХ
БОЛОН ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ
ТЭМЦЭХ
ТУХАЙ ХУУЛИЙН
3.1.1. ДЭХ
ЗААЛТАД



МӨНГӨ УГААХ-ЫН ТОДОРХОЙЛОЛТ

- Олон улсын стандарт буюу НҮБ-ын 2000 оны Палермогийн конвенцид “мөнгө угаах”-ыг дараах байдлаар тодорхойлжээ:
 - Гэмт хэргийн орлого гэдгийг нь мэдсээр байж эд хөрөнгийн хууль бус үүсвэрийг нуух, далдлах, эсхүл үндсэн зөрчлийг үйлдэхэд оролцсон этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх;
 - Гэмт хэргийн орлого гэдгийг нь мэдсээр байж эд хөрөнгийн бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, шилжүүлэх, эзэмших буюу бусад эрхийг нуух буюу далдлах;
 - Гэмт хэргийн орлого гэдгийг нь мэдсээр байж эд хөрөнгийг авах, эзэмших буюу ашиглах

ᠮᠣᠩᠭᠡ ᠤᠭᠠᠬᠤ



ГЭМТ ХЭРГЭЭС ОЛСОН ОРЛОГЫН УЧРУУЛЖ БУЙ ХОР ХӨНӨӨЛ

□ Мексикийн хар тамхины дайн

- 2006 оноос хойш 36000 хүн энэ дайнд үрэгдсэн
- Хар тамхины наймаанаас жилд \$13.6-аас \$48.4 тэрбум орлого олж байгаа
- Хар тамхины картелиудтай тэмцэхэд Мексикийн Ерөнхийлөгч Фелипе Калдерон цэрэг арми дайчлаад дийлэхгүй байна
- АНУ, Мексикийн банк, санхүүгийн байгууллагууд хар тамхины борлуулалтын орлогыг хүлээн авч, шилжүүлж, гүйлгээг хийж байсан нь тогтоогдсон.

Хар тамхины дайн



12/20/2012



مصرفی
عمومی



مصرف HSBC



МӨНГӨ УГААСАН БАНКУУДЫН ЖИШЭЭ

- ❑ Их Британий хамгийн том банк HSBC нь мөнгө угаасан тул АНУ-ын хууль хяналтынханд дэлхийн түүхэнд хамгийн их буюу 1,9 тэрбум ам.долларын торгууль төллөө. Банк нь хоригийн тухай хуулийг илт зөрчиж мөнгө угаахын эсрэг зохисгүй үйл ажиллагаа явуулж байсан гэдгээ хүлээн зөвшөөрсөн.
- ❑ Торгуулийн хэмжээ: \$1.92 тэрбум
- ❑ Огноо: 2012 оны 12 дугаар сарын 16-нд торгууль төлөгдсөн
- ❑ Хамрагдсан улс орнууд: Мексик, Иран, Куба, Саудын Араб

ᠮᠥᠨᠭᠦ ᠤᠭᠠᠰᠠᠨ ᠪᠠᠨᠬᠤᠭᠤᠳᠤᠨ ᠵᠢᠰᠡᠭᠡ



مصرفاً قياسياً



МӨНГӨ УГААСАН БАНКУУДЫН ЖИШЭЭ

- ❑ Стандарт Чартеред банк нь АНУ-ын эдийн засгийн хорионд орсон орнуудын жагсаалтад орсон дөрвөн улстай 2001-ээс 2007 оны хооронд бизнесийн харилцаатай байсан нь нотлогдсон тул АНУ-ын холбооны болон Нью-Йорк мужийн хууль хяналтынханд нийт \$667 сая ам.долларын торгуулийг төлсөн байна.
- ❑ “Стандарт Чартеред банк нь Судан, Иран зэрэг АНУ-ын хориотой оронд тооцогдсон бусад орны эсрэг гаргасан АНУ-ын хууль тогтоомжийг олон жилийн турш санаатайгаар зөрчиж байсан. АНУ нь өөрийн орны санхүүгийн системээс ихээхэн хэмжээний ашиг олдог санхүүгийн байгууллагуудаас сахилга батын минимум стандартыг мөрдөхийг шаардана. Стандарт Чартеред-н үйл ажиллагаа бол бүдүүлэг бөгөөд хүлээн зөвшөөрч боломгүй үйлдэл байсан” гэж АНУ-ын прокуророос мэдэгдсэн.
- ❑ Банк нь хорионд орсон улс дахь харилцагчиддаа хууль бусаар гүйлгээнүүдээ хэрхэн далдалж хийхийг зааж өгч хорионд орсон улсуудтай гүйлгээ хийгээгүй мэтээр СВИФТ код, гүйлгээний бусад мэдээллийг хуурамчаар хийж байсныг АНУ-ын хууль хяналтынхан тогтоосон.

ᠮᠣᠩᠭ᠎ᠠ ᠤᠭᠠᠭᠠᠰᠠᠨ ᠪᠠᠨᠴᠤᠭᠤᠳᠤᠨ ᠵᠢᠰᠡᠭᠡ





МӨНГӨ УГААСАН ТОМ ХЭРГҮҮДИЙН ЖИШЭЭ

Колумбын Пабло Эскобар. Дэлхийн кокаины худалдааны 80 хувийг түүний картель эзэмшиж байсан. 1989 онд түүний эд хөрөнгө 9 тэрбумаар үнэлэгдэж байсан. “Чи энд хэн нэгнийг хахуульд, тэнд хэн нэгнийг хахуульд, мөнгөө авахын тулд банкныхаа найзад мөнгө төл тэгээд л болоо” гэдэг байсан.

Индонезийн Ерөнхийлөгч асан Сухарто. Транспаренси интернэйшнэл түүнийг хамгийн том авилгачын жагсаалтад оруулсан. Тайм сэтгүүл түүний гэр бүлийн орлогыг 15 тэрбум ам.доллараар үнэлсэн байна. Энэ хөрөнгийнхөө 9 тэрбумыг нь Австрийн банкинд хадгалуулсан байжээ.

Филиппины Ерөнхийлөгч асан Фердинанд Маркос. Тэрбээр АНУ, Швейцарийн банкуудаар дамжуулж эх орноосоо хулгайлсан тэрбум тэрбум долларыг угааж байсан. Түүний эхнэр 2500 хос гуталтай байсан гэдгээрээ алдаршиж байсан. Филиппины хууль хяналтынхан дараа нь 7 тэрбум ам.долларыг буцааж авсан байна.

МОНГОЛ



МӨНГӨ УГААСАН ТОМ ХЭРГҮҮДИЙН ЖИШЭЭ

Франклин Журадо. 1996 онд Харвардад сургууль төгссөн Журадо нь өөрийн санхүү, эдийн засгийн мэдлэгийг ашиглаж Колумбын хар тамхины хаан Санта Круз Лондокогийн нэрийн өмнөөс 36 сая ам.долларыг төрөл бүрийн Европын банкуудаар дамжуулж угаасан байна.

“Venex”-ийн дуулиант хэрэг. Оросын мафийн мөнгийг АНУ-ын Нью Йоркийн банкин дахь “Venex Worldwide” компаний дансаар угааж байсан нь хуулийнханд баригдсан. Анхандаа Оросоос “хөрөнгө гадагшлах урсгал” бий болж байгаа мэт харагдаж байсан ч тэд буцаад Европын банкуудаар дамжиж Орос руу татагдсан байна. 1996 –аас 2002 оны хооронд нийтдээ 9 орчим тэрбум доллар дамжсан байгаа юм. Маш олон хүнийг энэ хэрэгтэй холбогдуулж барьсан байна.

Науру-гийн хэрэг. Науру нь Номхон далайд оршдог жижигхэн арал улс юм. Бага танигдсан энэ улс нь сүүлийн жилүүдэд харин дээд зэргийн мөнгө угаах үйл ажиллагаануудын төв нь болж байсан нь тогтоогдсон. 1990 ээд онд Оросын гэмт бүлэглэлүүд энэ улсаар дамжуулж 70 орчим тэрбум доллар угаасан байв. Ингэхдээ тэд Науруд бүртгэлтэй халхавч банкуудыг ашиглаж байжээ.

МОНГОЛ



МӨНГӨ УГААСАН ТОМ ХЭРГҮҮДИЙН ЖИШЭЭ

ВССІ-гийн дуулиан. Оргил үедээ Bank of Credit and Commerce International (ВССІ) нь дэлхийн 7 дахь хувийн банкинд тооцогдож байв. Гэвч 1980 аад оны дундуур тус банк маш их хэмжээний мөнгө угаах гэх мэт залилангийн үйл хэрэгт оролцож байсан нь тогтоогдсон. Хар тамхи гэх мэт гэмт хэргийн орлогууд энэ банкны дансаар дамжиж байв. Банк нь Саддам Хусейн, Панамагийн хуучин дарангуйлагч Мануэл Нориега, Палестиний террористын улирдагч Абу Нидал мэтийн хүмүүст үйлчилж байсан нь тус банк харилцагчаа ялгадаггүй болохыг нотолж байв. Түүнчлэн, 1980 оны үед ЗХУ-тас хийж байсан дайны үед АНУ-ын Тагнуулын байгууллага ВССІ ийн дансыг ашиглаж Афганы Мужахэдинуудыг санхүүжүүлж байсан нь илэрсэн.

Нигерийн Ерөнхийлөгч асан Сани Абача. Тэрбээр улс орноосоо 8 тэрбум доллар хулгайлж гадаадын банкуудад байршуулсан байна. Транспаренси интернэйшнэл түүнийг орчин үеийн дэлхийн түүхэнд 4 дэх том авилгач гэж нэрлэсэн. Тэрбээр Нигерийн үндэсний баялгийн 10 хувийг дээрэмдсэн. Түүнийг үхсэний дараа Нигерийн Засгийн газар 2 тэрбум долларыг нутагтаа буцааж авчирсан байна.

Маер Лански, Аль Капоне, Уотэргэйтийн хэрэг гэх мэт үргэлжилнэ.

ᠮᠣᠩᠭᠦ ᠤᠭ᠎ᠠᠰᠠᠨ ᠲᠣᠮ ᠬᠡᠷᠭᠦᠭᠦᠳᠢᠶᠢᠨ ᠵᠢᠰᠡᠭᠡ



МУ/ТС ТИПОЛОГИ

- ❑ **Авлигатай холбоотой (хээл хахууль, авлигын гэмт хэргийн орлого болон мөнгө угаахын эсрэг/терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУЖ/ТСТ) арга хэмжээг сулруулахад хүргэхүйц авлигын тохиолдлууд):** МУЭ/ТСТ арга хэмжээний хүчийг сулруулах улмаар мөнгө угаалтыг хөнгөвчлөхөд хүргэж болзошгүй авлига (албан тушаалтнуудад хахууль өгөх), үүнд улс төрийн нөлөөтэй хүмүүс (УТНХ)-ийн боломжит нөлөөлөл багтана: жишээлбэл, мөнгө угаалт явагдахыг зөвшөөрөн хээл хахууль авсан буюу нөлөөлөлд автсан албан тушаалтан эсвэл хувийн хэвшлийн банкны хэрэгжилт хариуцсан ажилтныг мөрдөн шалгах.
- ❑ **Валютын арилжаа/бэлэн мөнгөний хөрвүүлэлт:** илрүүлэлтийн эрсдлийг багасгахын тулд нөгөө улс орон руу зөөвөрлөх, эсвэл валютын арилжааны тайлагналтад сул шаардлага тавьдаг байдлыг ашиглах, тухайлбал мөнгийг өөр улс руу тээвэрлэхийн тулд замын чек худалдан авах.
- ❑ **Бэлэн мөнгө зөөвөрлөгчид/валют зөөвөрлөх:** гүйлгээний/бэлэн мөнгөний тайлагнах арга хэмжээнээс бултахын тулд валютыг нууцаар шилжүүлэх.
- ❑ **Мөнгө тушаах бүтцийг өөрчлөх (Structuring/smurfing):** Мэдээлэх үүрэг хүлээлгэн тогтоосон заагаас зайлсхийхийн тулд олон гүйлгээг (дансанд мөнгө тушаах, данснаас зарлагадах, шилжүүлгүүд) янз бүрийн хүмүүс их хэмжээний мөнгийг жижиг дүнтэйгээр зарим үед олон тооны дансанд шилжүүлэх арга юм.

МОНГОЛ
УЛСЫН
ХӨГЖИЛ
БАНК



ТИПОЛОГИ

- ❑ **Зээлийн картууд, чекүүд болон энгийн вексель (promissory note) г.м:** Ихэвчлэн өөр улсын санхүүгийн байгууллага дахь мөнгөнд/санд нэвтрэх хэрэгслээр ашигладаг.
- ❑ **Шилжүүлэх боломжтой үнэт эдлэлийг худалдан авах (үнэт чулуу, үнэт металл г.м):** Өмчлөлийг нь нуух, эсвэл илрүүлтэд өртөхгүй байдлаар зөөх болон санхүүгийн салбар дахь МУЭ/ТСТ арга хэмжээнээс зайлсхийх техник – жишээ нь очир эрдэнийг өөр улс руу зөөх.
- ❑ **Үнэтэй хөрөнгө худалдан авах (үл хөдлөх хөрөнгө, морин уралдаан, автомашин г.м):** Гэмт хэргийн орлогоор өндөр үнэ бүхий арилжих боломжтой бүтээгдэхүүнд хөрөнгө оруулалт хийснээр гэмт хэргээс олсон орлого гэдгийг нь нууж, тайлагнах шаардлагад бага хамааралтай байдлыг ашиглах.
- ❑ **Бараа солилцоо (бартер):** Санхүүгийн салбарын МУЭ/ТСТ арга хэмжээнээс зайлсхийхийн тулд мөнгө болон санхүүгийн хэрэгслийг хэрэглэхгүйгээр героиныг алтны гулдмайгаар шууд солилцох.
- ❑ **Бэлэн бус шилжүүлгийг хэрэглэх:** Илрүүлэлт болон хураан авах арга хэмжээнээс зайлсхийхийн тулд санхүүгийн байгууллагуудын хооронд ихэвчлэн нөгөө улс орон руу электрон шилжүүлэг хийх.

МОНГОЛ
УЛСЫН
ХӨГЖИЛ
БАНК



ТИПОЛОГИ

- ❑ **Нууц банк/албан бус гуйвуулгын үйлчилгээ(hawala, hundi г.м):** Итгэлцлийн сүлжээн дээр суурилсан албан бус механизмыг ашиглан мөнгө гуйвуулах. Голдуу уламжлалт банкны салбартай зэрэгцэн оршдог бөгөөд зарим улс оронд хууль бус (албан бус) гэж тооцогддог байна. Уг сүлжээг мөнгө угаагч болон терроризмыг санхүүжүүлэгч этгээдүүд ашиглан хөрөнгийг илрүүлтэнд өртүүлэхгүй, өөрсдийн хяналтанд буй мөнгөний гарал үүслийг нуун шилжүүлдэг **Худалдаанд суурилсан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх ажиллагаа:** санхүүгийн тунгалаг байдлын хууль зохицуулалтуудаас зайлсхийхийн тулд худалдааны санхүүжилтын замууд болон бараа бүтээгдэхүүнийг ашиглан ихэнх тохиолдолд нэхэмжлэхийг өөрчлөх.
- ❑ **Тоглоомын үйл ажиллагаанууд (казино, морин уралдаан, интернетээр бооцоотой тоглох г.м):** Мөнгөний эх үүсвэрийг нуун далдлах буюу хууль ёсны тоглогчоос хожлын тасалбарыг худалдан авах; казиногийн чипийг гэмт хэрэгтэй холбоотой гүйлгээнд төлбөрийн хэрэгсэл болгон хэрэглэх; онлайн мөрийтэй тоглоомыг гэмт хэргийн орлогыг нуухад ашиглах.
- ❑ **Ашгийн бус байгууллагыг ашиглах (ТББ):** Террорист санг өсгөн арвижуулах, мөнгөний эх үүсвэр болон мөн чанарыг нуун далдлах, террорист санг түгээхэд ашиглах.

МОНГОЛЫН
УЛАМЖЛАЛТЫН
БАНК



ТИПОЛОГИ

- ❑ **Санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх:** Арилжих боломжтой хэрэгслүүдийг худалдан авах замаар гэмт хэргийн орлогын эх үүсвэрийг нуун далдалж, тайлагналтын харьцангуй доогуур шаардлагыг ашиглах.
- ❑ **Холих (mingling=бизнесийн хөрөнгө оруулалт):** Мөнгө угаалтын үндсэн алхам буюу гэмт хэргийн орлогыг хууль ёсны мөнгөтэй нийлүүлэн эх үүсвэрийг нь нуун далдлах юм.
- ❑ **Халхавч компаниуд /корпорацуудыг ашиглах:** Хөрөнгийг хянаж буй этгээдийг таньж мэдэхээс зайлсхийж, тайлагналтын харьцангуй доогуур шаардлагыг ашиглах.
- ❑ **Оффшор банкууд/бизнесүүд, тухайлбал итгэлцлийн үйлчилгээ үзүүлэгч компанийг ашиглах:** хөрөнгийг хянаж буй этгээдийг таньж мэдэхээс сэргийлж, дотоодын эрх бүхий байгууллагын хориг хязгаарлалтаас зайлсхийхийн тулд мөнгийг шилжүүлэх.
- ❑ **Итгэмжлэгдэгч, итгэлцлүүд, гэр бүлийн гишүүд болон гуравдагч талуудыг ашиглах:** Хууль бус хөрөнгийг хянаж буй этгээдүүдийг таньж мэдэхээс сэргийлэх зорилготой.
- ❑ **Гадаадын банкны дансуудыг ашиглах:** Дотоодын эрх бүхий байгууллагын хориг хязгаарлалтаас холдуулах болон хууль бус хөрөнгийг хянаж буй этгээдийг таньж мэдэхээс зайлсхийхийн тулд мөнгийг шилжүүлэх.

ᠮᠡᠩᠭᠡ ᠪᠠᠨᠭ



ТИПОЛОГИ

- ❑ **Бусдын хувийн мэдээлэл/баримт бичгийг хулгайлан ашиглах/ (identity fraud/false identification):** мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх олон аргуудтэй холбоотой этгээдийг таньж мэдэхээс зайлсхийх.
- ❑ **Мэргэжлийн үйлчилгээний “хаалгач”-дыг ашиглах (хуульчид, нягтлан бодогчид болон боркерууд г.м):** Хөрөнгийн эцсийн өмчлөгчид болон хууль бус мөнгөний эх үүсвэрийг нуун далдлах зорилготой юм. Түүнчлэн гэмт хэрэгтнүүдэд мөнгө угаах “мэргэжлийн” зөвлөгөө өгөхөөр авлига авсан мэргэжилтнүүдийг хамааруулж болно.
- ❑ **Төлбөрийн шинэ технологиуд:** мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх сүүлийн үеийн төлбөрийн технологиуд. Жишээлбэл, гар утсанд суурилсан гуйвуулга болон төлбөрийн систем.

ᠮᠣᠩᠭᠣᠯᠢ
ᠪᠠᠨᠠᠭ



High-risk and non-cooperative jurisdictions FATF PUBLIC STATEMENT - 19 October 2012

Paris, 19 October 2012 - The Financial Action Task Force (FATF) is the global standard setting body for anti-money laundering and combating the financing of terrorism (AML/CFT). In order to protect the international financial system from money laundering and financing of terrorism (ML/FT) risks and to encourage greater compliance with the AML/CFT standards, the FATF identified jurisdictions that have strategic deficiencies and works with them to address those deficiencies that pose a risk to the international financial system.

Jurisdictions subject to a FATF call on its members and other jurisdictions to apply counter-measures to protect the international financial system from the on-going and substantial money laundering and terrorist financing (ML/TF) risks emanating from the jurisdictions. Iran Democratic People's Republic of Korea (DPRK) Jurisdictions with strategic AML/CFT deficiencies that have not made sufficient progress in addressing the deficiencies or have not committed to an action plan developed with the FATF to address the deficiencies. The FATF calls on its members to consider the risks arising from the deficiencies associated with each jurisdiction, as described below.

Bolivia
Cuba
Ecuador
Ethiopia
Indonesia
Kenya
Myanmar
Nigeria
Pakistan
São Tomé and Príncipe
Sri Lanka
Syria
Tanzania
Thailand
Turkey*
Vietnam
Yemen

مجلس
التعاون
الاسواق
الاقليمية
الاسياف



МОНГОЛД ХИЙЖ БАЙГАА ФАТФ-ЫН ХЯНАЛТ

Хийж байгаа ФАТФ-ын хяналт

1. Санхүүгийн мэдээллийн алба болон мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллага, Монголбанкны Хяналт шалгалтын газар, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг холбогдох байгууллагууд үйл ажиллагааны түвшинд /сэжигтэй гүйлгээг шалгах/ хамтран ажиллах механизмыг Санхүүгийн мэдээллийн албаны дэргэдэх Хамтын ажиллагааны зөвлөлийн дор байгуулах /2012 оны 6 дугаар сарын дотор/

2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийг гэмт хэрэгт тооцох (Зөвлөмж 1, Тусгай зөвлөмж II) ажлын хүрээнд:

2.1. Мөнгө угаахыг гэмт хэрэгт тооцох, түүнийг олон улсын стандартад нийцүүлэх үйл ажиллагааг өргөжүүлэх хүрээнд Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах (2012 оны 6 дугаар сар гэхэд төслийг боловсруулж дуусгах, 2012 оны эцсээс өмнө хүчин төгөлдөр болгох);

2.2. Мөнгө угаахтай холбоотойгоор хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын хамрах хүрээг өргөтгөх (2012 оны 6 дугаар сар гэхэд холбогдох хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулж дуусгах, 2012 оны эцэст хүчин төгөлдөр болгох);

2.3. Холбогдох хуулийн этгээдэд иргэний болон захиргааны хариуцлагын арга хэмжээ авахтай холбоотойгоор Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох журмуудад үр дүнтэй, тохирсон шийтгэлийн арга хэмжээ авах талаар тодорхой тусгаж, хэрэгжүүлэх (2012 оны 6 дугаар сар гэхэд холбогдох хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулж дуусгах, 2012 оны эцэст хүчин төгөлдөр болгох);



МОНГОЛД ХИЙЖ БАЙГАА ФАТФ-ЫН ХЯНАЛТ

Хийж байгаа

3. Сэжигтэй гүйлгээний тайланг мэдээлэх тогтолцоо (Зөвлөмж 13, Тусгай зөвлөмж IV)-г сайжруулах ажлын хүрээнд

3.1. Эрүүгийн хууль болон Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиуд дахь мөнгө угаах гэмт хэргийн үндсэн гэмт хэргийн төрөл болон гэмт хэргээс олсон орлогын хүрээг өргөжүүлэх, уг хамрах хүрээний дагуу Сэжигтэй гүйлгээний тайланг мэдээлэх **(2012 оны 6 дугаар сар гэхэд холбогдох хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулж дуусгах, 2012 оны эцэст хүчин төгөлдөр болгох);**

3.2. Ямар тохиолдолд гүйлгээг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой сэжигтэй гүйлгээ гэж үзэж Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх талаарх тодорхойлолтыг өргөжүүлэх асуудлаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах **(2012 оны 6 дугаар сар гэхэд төслийг боловсруулж дуусгах, 2012 оны эцэст хүчин төгөлдөр болгох);**

3.3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй гүйлгээ хийхийг оролдсон үед тухайн гүйлгээг мэдээлэх талаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулинд тодорхой заалт оруулах **(2012 оны 6 дугаар сар гэхэд холбогдох хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулж дуусгах, 2012 оны эцэст хүчин төгөлдөр болгох);**

3.4. Ирүүлж буй мэдээллийн тоо хэмжээ, чанарыг нэмэгдүүлэх зорилгоор мөнгө угаах арга, төрөл, типологийн ерөнхий чиг хандлагын талаар тодорхой хугацааны давтамжтайгаар сургалт зохион байгуулах, олон нийтэд мэдээлэл сурталчилгаа явуулах **(байнга)**



МОНГОЛД ХИЙЖ БАЙГАА ФАТФ-ЫН ХЯНАЛТ

ХИЙЖ БАЙГАА

4. Хөрөнгө хураах болон хөдөлгөөнгүй болгох арга хэмжээ (Зөвлөмж 3, Тусгай зөвлөмж III)-г ажлыг сайжруулах хүрээнд:

4.1. Түр зуурын болон хураах арга хэмжээг олон улсын стандарттай нийцүүлэн авч хэрэгжүүлэх талаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад холбогдох хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах; мөнгө угаах гэмт хэргийн үндсэн гэмт хэргээс олсон орлогоос шууд бусаар олж авсан хөрөнгийг оролцуулан “гэмт хэргээс олсон орлого”-ын тодорхойлолтыг гаргах **(2012 оны 6 дугаар сар гэхэд төслийг боловсруулж дуусгах, 2012 оны эцэст хүчин төгөлдөр болгох)**;

4.2. Тусгай зөвлөмж III-ыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор зохицуулах заавар журам бүхий хөрөнгө хураах систем бий болгох **(2012 оны 6 дугаар сар гэхэд төслийг боловсруулж дуусгах, 2012 оны эцэст хүчин төгөлдөр болгох)**;

4.3. Санхүүгийн мэдээллийн алба, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллага болон бусад холбогдох байгууллагуудын дунд терроризм, террорист үйл ажиллагаа, террорист байгууллагатай холбогдох хөрөнгийг хугацаа алдалгүй олж илрүүлдэг, хөдөлгөөнгүй болгодог үр дүнтэй механизм бий болгох **(байнга)**



МОНГОЛД ХИЙЖ БАЙГАА ФАТФ-ЫН ХЯНАЛТ

ᠮᠣᠩᠭᠣᠯᠳᠤ ᠬᠢᠶᠭ᠎ᠠ ᠮᠤᠨᠭᠡ ᠪᠣᠯᠠᠨ ᠦᠨᠢ ᠪᠦᠬᠢᠶᠢ ᠵᠢᠶᠢᠯᠰ ᠰᠢᠯᠵᠢᠵᠤᠯᠡᠬᠡ ᠶᠢᠯᠴᠢᠯᠭᠡ

5. Мөнгө болон үнэ бүхий зүйлс шилжүүлэх үйлчилгээ (Тусгай зөвлөмж VI)-нд хяналт тавих ажлын хүрээнд

5.1. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хүрээнд мөнгө болон үнэ бүхий зүйлс шилжүүлэх үйлчилгээ үзүүлэгч хувь хүн, төлөөлөгч болон хуулийн этгээдийг бүртгэдэг эсхүл тусгай зөвшөөрөл олгодог болох, тэдгээрийг Санхүүгийн зохицуулах хороо юмуу эсхүл өөр холбогдох байгууллагын зохицуулалтанд оруулж, хяналт тавьдаг болох **(2012 оны эцэс гэхэд холбогдох хуулийн төслүүдийг боловсруулж, 2013 оны 6 дугаар сар гэхэд хүчин төгөлдөр болгох);**

5.2. Мөнгө болон үнэ бүхий зүйлс шилжүүлэх үйлчилгээ үзүүлэгчдийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зохицуулалтанд оруулсны дараа гаргах журам болон Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулинд цахим шилжүүлэг хийх үед харилцагчийг таньж мэдэх шаардлагатай арга хэмжээ авах талаар тодорхой тусгах **(2012 оны 6 дугаар сар гэхэд төслийг боловсруулж дуусгах, 2012 оны эцэст хүчин төгөлдөр болгох);**

5.3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор тусгай зөвшөөрөл авсан гуйвуулга/шилжүүлэгийн үйлчилгээ үзүүлэгч банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх **(байнга)**



МОНГОЛД ХИЙЖ БАЙГАА ФАТФ-ЫН ХЯНАЛТ

6. Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба болон Санхүүгийн зохицуулах хороонд шаардагдах сургалт, хүний нөөц

6.1. Санхүүгийн мэдээллийн алба Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх үүднээс шинжээч, хянан шалгагчийн орон тоог нэмэгдүүлэх **(байнга)**

6.2. Санхүүгийн зохицуулах хороо банкнаас бусад санхүүгийн байгууллагад хяналт шалгалт хийх болон тэдгээрийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх үүднээс хянан шалгагчийн орон тоог нэмэгдүүлэх **(байнга)**

6.3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнууд, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч нарт зориулан сургалт зохион байгуулах **(байнга)**

ᠮᠣᠩᠭᠣᠯᠳᠤ ᠬᠢᠶᠭ᠎ᠠ ᠪᠠᠶᠢᠭᠠᠭ᠎ᠠ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠢᠯᠢ ᠠᠯᠤᠪᠠ



ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

- **Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулинд оруулахыг санал болгож байгаа томоохон өөрчлөлтүүд:**
 - 3.1.1. “мөнгө угаах” гэж гэмт хэрэг үйлдэж олсон орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийг олж авах, эзэмших, ашиглах, эсхүл тухайн эд хөрөнгийн бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, хэлбэр, тухайн эд хөрөнгөтэй холбоотой өмчлөх эрх болон бусад эрхийг нуун далдлах, эсхүл хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах, түүнчлэн аливаа этгээдийг хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор эд хөрөнгийг гэмт хэрэг үйлдэж олсон орлого гэдгийг мэдсээр байж өөрчлөх, шилжүүлэх;
 - 3.1.6. “Төрийн өндөр албан тушаалтан” гэж Монгол Улсын эсхүл гадаад улсын Төр, Засгийн газрын тэргүүн, улс төрийн нам, яам, агентлаг, шүүх, прокурор, төрийн өмчит компани, олон улсын байгууллагын удирдах албан тушаал эрхэлж байгаа эсхүл эрхэлж байсан хүн, түүний гэр бүлийн гишүүн;
 - 3.1.7. “эцсийн өмчлөгч” гэж хуулийн этгээдийн толгой компанийг эцэст нь өмчилж, хувь хүнийг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар хийлгэж байгаа хүн, эсхүл аливаа нэг хуулийн этгээд, хэлцлийг эцэст нь хянаж байгаа хүнийг;
 - 3.1.8. “халхавч банк” гэж аливаа нэг улс оронд бүртгэлтэй боловч тэндээ биетээр оршдоггүй банкийг;



ᠮᠣᠩᠭᠣᠯ
ᠪᠠᠨᠠᠭ



ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

3.1.9. "харилцагчийн талаарх мэдээллийг шалгах" гэж мэдээлэх үүрэгтэй этгээд нь өөрийн харилцагчийн овог, нэр, холбогдох бусад мэдээллийг түүнээс гаргуулах, мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулах зорилгоор бичиг баримттай нь тулган шалгахыг тус тус хэлнэ.

4.1. Дараах этгээд энэ хуулийн [7 дугаар зүйл](#)д заасан гүйлгээний талаар Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй:

4.1.1. банк;

4.1.2. банк бус санхүүгийн байгууллага;

4.1.3. даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;

4.1.4. хөрөнгө оруулалтын сан

4.1.5. үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;

4.1.6. хадгаламж, зээлийн хоршоо;

4.1.7. үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага

4.1.8. нотариатын үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд

5.2.4. харилцагчийн эцсийн өмчлөгчийн овог, нэрийг тодорхойлж уг эцсийн өмчлөгчийн хэн болох, өмчлөл, хяналт, зохион байгуулалтын бүтцийг таньж мэдэхтэй холбоотой боломжит бүх арга хэмжээг авах

ᠮᠣᠩᠭᠡᠯᠠᠭᠤᠨ
ᠪᠠᠨᠭᠠ



ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

5.2.6. банк, санхүүгийн байгууллагын хоорондын цахим шилжүүлэг хийсэн хувь хүний овог нэр, регистрийн дугаар, гадаадын иргэн, харьяалалгүй этгээдийн хувьд гадаад паспортын дугаар.

5.7. Энэ хуулийн 4.1-т заасан этгээд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон бизнесийн харилцаа, гүйлгээнүүдэд өндөржүүлсэн харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

6 дугаар зүйл. Тусгай хяналт

6.1. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь дараах гүйлгээнд тусгайлан хяналт тавих үүрэгтэй:

6.1.1. ердийн бус их дүнтэй гүйлгээ;

6.1.2. нарийн төвөгтэй гүйлгээ;

6.1.3. эдийн засаг, хууль ёсны илт зорилгогүй;

6.1.3. төрийн өндөр албан тушаалтны нэр дээр хийгдсэн;

6.1.4. мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой улсаар дамжуулан хийсэн гүйлгээ зэрэг байна.

МОНГОЛ УЛСЫН
ЗАСАГ ЗАР



ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

7 дугаар зүйл. Гүйлгээний талаар мэдээлэх

7.1. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.

7.2. Мөнгө, хөрөнгийг гэмт хэрэг үйлдэж олсон орлого, эсхүл мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд сэжиглэсэн эсхүл мэдсэн тохиолдолд сэжигтэй гэж үзсэнээс хойш 24 цагийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлнэ. Ингэхдээ гүйлгээ хийх оролдлогыг мөн хамруулна.

ᠮᠣᠩᠭᠣᠯᠢ ᠪᠠᠨᠠᠭ



ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

11 дүгээр зүйл. Гүйлгээг түр зогсоох, хөрөнгө битүүмжлэх, түдгэлзүүлэх

11.4. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолд террорист гэж зарлагдсан эсхүл хориг арга хэмжээ авахаар заасан хувь хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бусаар эзэмшиж байгаа гүйлгээ, данс, эд хөрөнгийг нэн даруй битүүмжилж Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

11.5. Энэ хуулийн 11.4-т заасан данс, гүйлгээг түдгэлзүүлэх, хөрөнгийг битүүмжлэх, битүүмжилсэн хөрөнгөөс гуравдагч гэм буруугүй этгээдэд ашиглуулах, хувь хүн, хуулийн этгээдийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн нэрсийн жагсаалтад оруулах, түүнээс хасах журмыг Сангийн Сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Улсын Ерөнхий Прокурор ын хамтран батална.

ᠬᠤᠯᠡᠭᠡᠳᠡᠵᠢ ᠪᠤᠶᠢ ᠡᠷᠬᠡ ᠵᠦᠶᠢᠨ ᠰᠢᠨᠡᠴᠯᠡᠯ



ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

14 дүгээр зүйл. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналт

14.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын хөтөлбөр баталж мөрдүүлэх бөгөөд түүнд дараахь зүйлийг тусгана:

14.1.4. аудитаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр, журмын хэрэгжилтийг тогтмол шалгуулдаг байх;

14.1.5. өөрийн харилцагч үйлчилгээ, бүтээгдэхүүний мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлж, өндөр эрсдэлтэй харилцагч, бүтээгдэхүүн, үйлчилгээнд онцгой анхаарал тавихад чиглэх.

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ



ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

16 дугаар зүйл. Санхүүгийн мэдээллийн алба

16.1. Санхүүгийн мэдээллийн алба нь энэ хуулийн 4.1-т заасан этгээдээс энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх сэжигтэй гэж үзсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан Үндэсний төв байгууллага байна.

Засаг захиргаа



ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

18.2. Энэ хуулийн 18.1-д заасан хяналт тавих, хэрэгжилтийг хангуулахдаа Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

18.2.1. энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн удирдлага, үйл ажиллагаанд шууд ба шууд бус байдлаар оролцох, удирдах, эзэмшихэд тохирсон, энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохистой шалгуурыг бий болгоход шаардлагатай арга хэмжээг авах;

18.2.2. энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн энэ хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалт хийх;

18.2.3. энэ хуульд заасан үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэх зорилгоор энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд зориулж заавар, дүрэм, журам, удирдамж, зөвлөмж гаргах;

18.2.4. эрх бүхий бусад байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох мөн мөнгө угаах, үндсэн гэмт хэрэг, терроризмийг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбогдсон мөрдөн байцаалт, хэрэг мөрдөлт, шүүх ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх;

18.2.5. сэжигтэй гүйлгээг мэдээлэхэд тохирсон стандарт, шалгууруудыг Санхүүгийн мэдээллийн алба, эрх бүхий байгууллагатай хамтран боловсруулах;

18.2.6. энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж авч байгаа арга хэмжээ болон ноогдуулж буй хариуцлагын талаарх статистик мэдээг олон нийтэд түгээх;

18.2.7. мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбогдсон байж болох сэжигтэй гүйлгээнүүд болон баримт бичгийн талаарх аливаа мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд шуурхай мэдээлэх.

ᠮᠣᠩᠭᠣᠯᠪᠠᠨᠭ



ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

22.1.1. энэ хуулийн 4.3, 5.3, 5.7, 6, 7, 10.2, 13.3 заасныг зөрчсөн албан тушаалтныг ххххххх хүртэл, хуулийн этгээдийг хххххххх хүртэл төгрөгөөр торгох;


22.1.2. энэ хуулийн 13 дугаар зүйлд заасныг зөрчсөн хувь хүнийг хххххх хүртэл, албан тушаалтныг хххххххх хүртэл, хуулийн этгээдийг хххххххх хүртэл төгрөгөөр торгох;

22.1.3. Энэ хуулийн 15.1-т заасан мэдүүлэг гаргахаас зайлсхийсэн, татгалзсан, эсхүл худал мэдүүлсэн бол хххххх төгрөгөөр торгох .

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ



САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ХАРИЛЦАГЧАА ХЭР ТАНИХ ВЭ



Хөгжлийн Банк

Банкаар жилд 24 сая ам.доллар эргэлдүүлдэг харилцагчийн тухайн банкинд бүртгүүлсэн компанийх нь хаягаар очиход нэг иймэрхүү байх жишээтэй



AMLCFT COMPLIANCE REGIME

- ❑ Know your customer – Харилцагчаа таних
- ❑ Suspicious transaction reporting – Сэжигтэй гүйлгээний талаар мэдээлэх
- ❑ Identify and verify PEP – Улс төрийн өндөр албан тушаалтныг таних, шалгах
- ❑ Identify and verify Beneficial owner – Компаний эцсийн өмчлөгчийг таних, шалгах
- ❑ Risk assessment – enhanced due diligence – Эрсдлийн үнэлгээ – өндөржүүлсэн шалгалт
- ❑ Record keeping – Баримт хадгалах
- ❑ Internal monitoring – Дотоод хяналт
- ❑ Supervision – Хяналт шалгалт

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ



مەنڧول بانكى

БАЯРЛАЛАА